



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2001 оны 01 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Бүтцийн өөрчлөлт хийх, дүрэм,
орон тоо батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

Нэг. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан "Залуучуудын ордон"-г 2001 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс татан буулгаж, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бүтцэд "Нийслэлийн хүүхэд, залуучуудын ордон" нэртэйгээр ажиллуулсугай.

Хоёр. "Нийслэлийн хүүхэд залуучуудын ордон"-г өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллуулахыг Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ц.Цогзолмаа/-т зөвшөөрсүгэй.

Гурав. Л.Ганзоригтыг 2001 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөр тасалбар болгон Залуучуудын ордны захирлын үүрэгт ажлаас чөлөөлж, Хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэдэлд шилжүүлсүгэй.

Дөрөв. Нийслэлийн Хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

Тав. Хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг хоёр орлогч даргатай /орлогч дарга бөгөөд хэлтсийн дарга, орлогч дарга бөгөөд ордны захирал/, Хүүхэд, залуучуудын хэлтэстэй, орон тооны хязгаарыг 11 /үйлчилгээний орлогоос цалинждаг болон нормативаар ажиллах орон тоо орохгүй/ хүртэл байхаар тогтоосугай.

Зургаа. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэнтэй холбогдуулан Хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харъяанд ажиллаж байгаа хороодын хүүхэд залуучуудын асуудал эрхэлсэн ажилтнуудыг 2001 оны 1 дүгээр сарын 1-нээс тооцон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын мэдэлд хороодын нийгмийн ажилтнаар орон тоо, цалингийн сангийн хамт шилжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн бодлогын хэлтэс /Д.Ганболд/, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ц.Цогзолмаа/-т үүрэг болгосугай.

Долоо. Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтааж албан хаагчдыг томилж, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоож, байгууллагын дотоод журмыг шинэчилж мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулж ажиллахыг Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ц.Цогзолмаа/-т үүрэг болгосугай.


Найм. Хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай өмч ашиглалтын гэрээ байгуулан хяналт тавьж ажиллахыг Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнаран/, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс /Ш.Наран/- т үүрэг болгосугай.

Ес. Өмч хөрөнгө болон ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|----------------------|--------------|--|
| Комиссын дарга | Ш.Наран | -Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга | Б.Лхамсүрэн | -Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн зохион байгуулагч |
| Гишүүд | Н.Болормаа | -Өмчийн харилцааны газрын мэргэжилтэн |
| | Ж.Наранцэцэг | -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн зохион байгуулагч |
| | Б.Норжинлхам | -Санхүүгийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн |
| | Х.Цамбаа | -Залуучуудын соёлын төвийн нягтлан бодогч |

Арав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/18 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



М.ЭНХБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2001 оны
18 дугаар захирамжийн хавсралт

ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /цаашид "Газар" гэх/ нь нийслэлийн нутаг дэвсгэрт хүүхэд залуучуудын талаар Монгол Улсын Засгийн газраас явуулах бодлого болон Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газар нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоол шийдвэр, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлагад үйл ажиллагаагаа явуулж ажлаа тайлагнана.

1.4. Нийслэлийн Засаг дарга нь Газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоож, газрын даргыг томилж, чөлөөлнө.

1.5. Газрын дарга нь нийслэлийн Засаг даргатай зөвшилцсэний үндсэн дээр орлогч даргаа томилж, чөлөөлнө.

1.6. Газрын дарга нь Монгол улсын хууль, тогтоомж, удирдах дээд байгууллагын шийдвэрт нийцсэн тушаал гаргаж, биелэлтийг хангуулна.

1.7. Газрын дарга нь батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж чөлөөлнө.

1.8. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батална.

1.9. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.10. Газар нь хүүхэд, залуучуудад мэдлэг боловсрол олгох, авъяас чадварыг дэмжих чиглэлээр "сан"-тай байж болно.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2.Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3.Хүүхэд, залуучуудын талаар төрөөс болон Нийслэлээс баримтлах бодлого, энэ чиглэлээр гарсан хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.4.Хүүхэд, залуучуудын асуудлаар төрөлжсөн судалгаа хийж, дүгнэлтүүдийг гарган, энэ чиглэлээр хийх ажлуудыг тодорхой төлөвлөж хэрэгжүүлэх.

2.5.Хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийг асран хамгаалах, туслах, залуучуудын ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн асуудалд тусгай хөтөлбөр боловсруулан ажиллах.

2.6.Харъяа газрууд ба хамтран ажилладаг байгууллагуудын болон анхан шатны байгууллагынхаа ажилтнуудыг мэргэжлийн хувьд чадваржуулах, давтан сургах, дадлагажуулах, арга зүйн болон мэргэжлийн удирдлагаар хангах, боловсон хүчний нөөцийн бодлого боловсруулах, зөвлөлгөө өгөх.

2.7.Хүүхэд, залуучуудын зориулалттай баригдсан барилга байгууламжийг зориулалтаар нь ашиглах, материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарч улмаар тэдгээрийг түшиглэн хүүхэд залуучуудад зориулсан уран бүтээлийн ба сургалт, төвлөрсөн арга хэмжээ болон бусад олон төрлийн ажлыг зохион байгуулах.

2.8.Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэхэд чиглэгдсэн төслүүдийг боловсруулж, зохих газруудад уламжлан дэмжүүлэн, хэрэгжүүлэх.

2.9.Хүүхэд, залуучуудын нийтлэг эрх ашгийг хамгаалах, гэдэнтэй холбогдсон байгууллага, иргэдийн санал, өргөдөл гомдлыг хүлээн авч зохих газруудад уламжлан шийдвэрлүүлэх.

2.10.Эрхэлж буй ажлын хүрээнд хамаарах зайлшгүй шаардлагатай асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

2.11.Эмэгтэйчүүд, гэр бүлийн асуудлаар тодорхой саналууд боловсруулж үйл ажиллагаа явуулах.

2.12.Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

2.13.Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

2.15. Хүүхдийн хөдөлмөр, хүмүүжил сургалтын төвийн сургалт хүмүүжлийн ажилд хяналт тавьж, хүүхдийн эрхийг хамгаалах, тэднийг гэр бүл, сургуулийн хамт олны дунд хүмүүжих нөхцлийг бүрдүүлэхэд судалгаа дүгнэлттэй ажиллах.

2.16. Хүүхэд, залуучуудын асуудлыг хариуцан ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай ажлаа уялдуулж хамтран ажиллах.

Гурав. Газрын эрх

3.1. Хүүхэд, залуучуудын талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг нийслэлд хэрэгжүүлэхтэй холбогдсон саналыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тавьж шийдвэрлүүлэх.

3.2. Нийслэлийн дүүрэг, хороодод хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн зохион байгуулагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагааны тайлан сонсголыг хэлэлцэн үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах, зөрчил дутагдлыг арилгуулах.

3.3. Эрхэлсэн асуудалтай холбоотой судалгаа, баримт материалыг төрийн захиргааны болон бусад байгууллагуудаас тогтоосон журам, эрх хэмжээний дагуу гаргуулан үйл ажиллагаандаа хэрэглэх.

3.4. Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилт, төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, газрын батлагдсан төсвийг захиран зарцуулж, тайлагнах.

3.5. Харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилох, томилоход санал өгөх, тэдний ажлын талаар санал дүгнэлт гаргах.

3.6. Харьяа байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, тэдгээрийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу нийслэлийн Засаг даргын Тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх.

3.7. Нийслэлийн хүүхэд, залуучуудын асуудлаар бусад төрийн болон төрийн бус байгууллага ба Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэх.

3.8. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.9. Хүүхдийн зуслангуудын үйл ажиллагааг нь мэргэжлийн удирдлагаар хангах.

3.10. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.